



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 27 өдөр

Дугаар А/498

Есөнбулаг

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалт, 46.3 дахь хэсэг, Үнэлгээний хорооны 2023 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 48 дугаар зөвлөмжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжигдэх ГААОНӨГ/202304029 дугаар Нэгдсэн эмнэлэгт бараа материал нийлүүлэх ажлыг гэрээ байгуулан гүйцэтгүүлэх эрхийг аймгийн Нэгдсэн эмнэлэг (Д.Сэлэнгэ)-т олгосугай.

2.Ажил гүйцэтгэх хугацаа, ажлын тоо хэмжээг үндэслэн холбогдох хууль, журмын дагуу эрх, үүрэг, захиалагчийн хяналт, хариуцлагыг гэрээнд тодорхой тусгаж, хэрэгжилтийг тайлагнаж ажиллахыг аймгийн Нэгдсэн эмнэлэг (Д.Сэлэнгэ)-т үүрэг болгосугай.

3.Ажлын гүйцэтгэл, чанар, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (С.Мөнхжаргал), Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг), Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ)-т тус тус даалгасугай.

ОРЛОГЧ

Г.ЧИНБАТ

